Орчин цагийн уламжлалт анагаахын эмч бэлтгэхэд профессор Н.Төмөрбаатарын оруулсан хувь нэмрийг тодруулах нь

Ц.Уянга[1], Р.Байгалмаа[2], Д.Цэрэндагва[1]

[1]АШУҮИС, МАУОУС
[2]Хэнтий аймаг, Уламжлалт анагаах ухааны эмнэлэг
Цахим шуудан: Ubono2727@yahoo.com, Утас: 99152079

Түлхүүр үг:

Профессор Н.Төмөрбаатар
Монголын уламжлалт анагаах ухаан

Товч утга: Монгол Улсын эрүүл мэндийн салбарын тогтолцооны үндэс тавигдсан цаг үеэс өрнө, дорнын анагаах ухааныг зэрэгцүүлэн хөгжүүлж байсан туршлага байсан хэдий ч нийгмийн гажуудлын нөлөөнд өртөж хөгжил нь зогсонги байдалд орон уламжлалт анагаах ухааныг дахин сэргээн хөгжүүлж, төрийн бодлогын түвшинд хүргэхэд анагаах ухааны доктор, профессор Н.Төмөрбаатар түүхэн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ цаг үед тус салбарын хөгжлийн талаар тулгамдаж буй асуудалд түүний алсын хараа, туршлагаас суралцах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа билээ. Уламжлалт анагаах ухааны дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд Монгол Улсын Хүний гавьяат эмч, Монголын анагаах ухааны академийн гишүүн, академич, доктор, профессор Н.Төмөрбаатарын дээд боловсрол, шинжлэх ухаан, анагаах ухааны салбарт оруулсан хувь нэмрийг судлах зорилгоор уг судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Профессор Н.Төмөрбаатарын эрдэм судлалын бүтээлийг товчоолоход удирдаж хамгаалуулсан доктор 15, шинжлэх ухааны магистр 18, оюуны өмч 7, хэрэгжүүлсэн төсөлт ажил 5, илтгэлийн хураангуй 97, олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл 37, өгүүлэл 19, ном сурах бичиг 19, редактор хийсэн ном 19 байна. Түүний шавь нараас Шинжлэх ухааны академийн гишүүн 1, Монголын анагаах ухааны академийн гишүүн 3, анагаахын шинжлэх ухааны доктор 3, анагаах ухааны доктор 14 төрсөн байна. Монгол Улсын Эрүүл мэндийн салбарт орчин цагийн уламжлалт анагаах ухааны хүний их эмч бэлтгэх сургалтын төлөвлөгөөг боловсруулж анхны эмч нарыг бэлтгэсэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд уламжлалт анагаах ухааны шинэ салбарыг нэвтрүүлсэн, уламжлалт анагаах ухааны анхны эрдэмтдийг төрүүлж, уламжлалт анагаах ухааны орчин цагийн дэг сургуулийг үүсгэн байгуулсан нэрт сурган хүмүүжүүлэгч багш, шилдэг эрдэмтэн судлаач, мэдрэл ба уламжлалтаар мэргэшсэн тэргүүлэх профессор мөн.

Үндэслэл: Монгол Улсад Мамба дацан буюу анхны эмнэлгийн сургуулиуд 1585 оноос үүсэн байгуулагдсан бөгөөд 1920 он гэхэд тэжээхүйн ухааны боловсрол олгодог, эмч бэлтгэх сургалттай 203, маарамбын дамжаа барьдаг 6 гэсэн нийт 222 буддын гүн ухаан сургууль байсан. 1937 оны 3 дугаар сарын 13-нд Засгийн Газраас Үндэсний клиник эмнэлгийг хаах шийдвэр гаргаж уламжлалтын эмнэлэг, төвөд эмийн сангуудыг хаасан. 1959 онд Шинжлэх ухаан дээд боловсролын хүрээлэнд "Эм судлалын лаборатори" байгуулагдаж уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэж байсан эмийн ургамлыг судлах ажлыг эхлүүлсэн нь уламжлалт анагаах ухаанд хэрэглэж байсан эмийн ургамлуудын зэрэгцээ амьтан, эрдсийн гаралтай эмт бодисын судалгааны ажил хийхэд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд уг лаборатори нь одоо Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн болон өргөжин хөгжсөн.[8]

Монгол Улсын эрүүл мэндийн салбарын тогтолцооны үндэс тавигдсан цаг үеэс өрнө, дорнын анагаах ухааныг зэрэгцүүлэн хөгжүүлж байсан туршлага байсан хэдий ч нийгмийн гажуудлын нөлөөнд өртөж хөгжил нь зогсонги байдалд орон уламжлалт анагаах ухааныг дахин сэргээн хөгжүүлж, төрийн бодлогын түвшинд хүргэхэд анагаах ухааны доктор, профессор Н.Төмөрбаатар түүхэн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ цаг үед тус салбарын хөгжлийн

талаар тулгамдаж буй асуудалд түүний алсын хараа, туршлагаас суралцах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа билээ.[9]

Зорилго: Уламжлалт анагаах ухааны дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд Монгол Улсын Хүний гавьяат эмч, Монголын анагаах ухааны академийн гишүүн, академич, доктор, профессор Н.Төмөрбаатарын дээд боловсрол, шинжлэх ухаан, анагаах ухааны салбарт оруулсан хувь нэмрийг судлах зорилгоор уг судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Арга, аргачлал: Бид чанарын судалгааны аргыг ашиглан анагаах ухааны доктор, профессор Н.Төмөрбаатарын талаар өгүүлсэн тэмдэглэл, сонин, сэтгүүл, ном, фото зургийн агуулгад буй тухайн зохиогчийн яриа, нийтлэлийг судалгаанд ашиглав. Багш Н.Төмөрбаатарын тухай хийсэн баримтат кино, бусад түүхэн видео, аудио бичлэгүүдэд үлдээсэн ярилцлага болон хувийн цуглуулга дахь эх хэрэглэгдэхүүнүүд, гар бичмэлүүдийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх, Контент-анализ, хүүрнэмжийн аргаар түүний үүсгэн байгуулсан дэг сургуулийн хөгжлийн талаар асуумжаар тодруулж, нэгтгэн дүгнэсэн.

Үр дүн, хэлцэмж: 1989 онд Анагаах Ухааны Дээд Сургууль Монголын Уламжлалт анагаахын тэнхим байгуулагдаж өрнийн болон Монголын Уламжлалт Анагаах Ухааны хосолсон их эмч бэлтгэж эхэлсэн байна. Анагаах Ухааны Дээд Сургууль нь 1990 онд Монгол Улсын Засгийн Газрын тогтоолоор Анагаах Ухааны Их Сургууль болсон ба Монгол оронд Ардчилал, чөлөөт зах зээлийн тогтолцоо руу шилжин, олон ургалч үзэл хөгжиж, олон намын тогтолцоо бий болж, эрүүл мэндийн үйлчилгээнд өрхийн эмнэлгийн тогтолцоо, эрүүл мэндийн даатгал нэвтэрч, урьдчилан сэргийлэх анагаах ухааныг түлхүү хөгжүүлэх төрийн бодлого биеллээ олсон үед хөгжлийн шинэ нөхцөлд, шинэ арга барилаар ажиллах мэргэжилтнийг бэлтгэх хүндтэй бөгөөд хариуцлагатай үүрэг хүлээсэн.[10] Ийм ч учраас тус их сургууль нь 50 гаруй жил хэрэглэж замнаж ирсэн хөгжлийн бодлого, эмч бэлтгэх сургалтын бодлогодоо шинэчлэл хийж, олон жилийн түүхтэй тэнхим нэгжүүдийн бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөн Анагаах ухааны сургууль, Нүүр ам судлалын сургууль, Уламжлалт анагаах ухааны сургуулийг шат дараалан үе шаттай байгуулж эхэлсэн.

Эрүүлийг хамгаалах яамны харьяа Анагаах Ухааны Дээд сургуулийн ректорын 1989 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн дугаар А/98 тоот тушаалаар Улсын клиникийн төв эмнэлгийн Ардын эмнэлгийн салбарын эрхлэгчээр мэдрэл судлалын тэнхимийн багш Н.Төмөрбаатарыг томилж ажиллуулсан анхны уламжлалт анагаах ухааны эмнэлгийн тусламж үйлчилгээг тусад нь зохион байгуулсан түүхэн шийдвэр болсон. [7]

Эрүүлийг хамгаалах яамны харьяа Анагаах Ухааны Дээд сургуулийн ректорын 1990 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн дугаар А/54 тоот тушаалаар Уламжлалт анагаах ухааны тэнхимийг шинээр байгуулж, дэд эрдэмтэн Н.Төмөрбаатарыг тэнхимийн эрхлэгчээр томилсон. Анхны багшаар П.Хажидсүрэн, С.Өлзийсайхан, Ж.Болормаа нар ажиллаж байлаа. [7]

Анхны сургалтын төлөвлөөг 1989-1990 оны хичээлийн жилд боловсруулан 1990-1991 оны хичээлийн жилд анхны элсэн сурагчдыг эмчилгээ, хүүхэд, шүдний ангийн 3 дугаар дамжааны оюутнуудаас элсүүлэн 3 жилээр бэлтгэж эхэлсэн. Жил бүрийн элсэлтийг дамжаа багасгаж элсүүлснээр 6 жилийн анхны уламжлалтын эмч нар 1998 онд төгссөн.

Анхны сургалтын төлөвлөгөөг боловсруулахад БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны багш нарын оролцоо их байсан бөгөөд онолын үндэс, жор судлал, оношилгоо, дотор засал, таван засал хичээлийн Өвөр Монголын багш нарын гаргасан сурах бичгээс боловсруулан зааж байсан. Орчин үеийн анагаах ухааны клиникийн гол хичээл мэс засал, дотор өвчин, эх барих эмэгтэйчүүд, халдварт өвчин, гэмтэл, яаралтай тусламжийн хичээлийг анагаах ангийн оюутантай ижил түвшинд зааж байсан.

Н.Төмөрбаатар багш, уламжлалт анагаах ухааны тэнхимийн багш нарын боловсруулсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь амжилттай хэрэгжиж Монгол Улсад анх удаа магадлан итгэмжлэгдсэн.

Н.Төмөрбаатар багш уламжлалт анагаах ухааны тэнхимийн багш нарыг бэлтгэх, эрдэм судлалын ажил хийх, эмнэлэгт эмчээр ажиллаж, дадлагажихад маш их санаачилгатай ажиллаж тэнхимийн нараас Д.Цэрэндагва 2000 онд анх удаа анагаах ухааны докторын зэрэг хамгаалж 2013 он гэхэд нийт багш нарын 70% нь эрдмийн зэрэг цолтой болсон.

Сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг өргөжүүлэн уламжлалт анагаах ухааны эмч бэлтгэх сургалтын төлөвлөгөөг 2 дахь удаа магадлан итгэмжлүүлж, төгсөлтийн магистрын сургалтын хөтөлбөрийг анх удаа магадлуулсан, зүү төөнө заслын эмч, уламжлалт анагаахын засалч зэрэг гадаадын их дээд сургуультай хамтарсан хоёр хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна.

Профессор Н.Төмөрбаатарын эрдэм судлалын бүтээлийг товчоолоход удирдаж хамгаалуулсан доктор 15, шинжлэх ухааны магистр 18, оюуны өмч 7, хэрэгжүүлсэн төсөлт ажил 5, илтгэлийн хураангуй 97, олон улсын хуралд хэлэлцүүлсэн илтгэл 37, өгүүлэл 19, ном сурах бичиг 19, редактор хийсэн ном 19 байна. Түүний шавь нараас Шинжлэх ухааны академийн гишүүн 1, Монголын анагаах ухааны академийн гишүүн 3, анагаахын шинжлэх ухааны доктор 3, анагаах ухааны доктор 14 төрсөн байна.

Дүгнэлт: Монгол Улсын Эрүүл мэндийн салбарт орчин цагийн уламжлалт анагаах ухааны хүний их эмч бэлтгэх сургалтын төлөвлөгөөг боловсруулж анхны эмч нарыг бэлтгэсэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд уламжлалт анагаах ухааны шинэ салбарыг нэвтрүүлсэн, уламжлалт анагаах ухааны анхны эрдэмтдийг төрүүлж, уламжлалт анагаах ухааны орчин цагийн дэг сургуулийг үүсгэн байгуулсан нэрт сурган хүмүүжүүлэгч багш, шилдэг эрдэмтэн судлаач, мэдрэл ба уламжлалтаар мэргэшсэн тэргүүлэх профессор мөн.

Ном зүй:

1. *Ц.Лхагвасүрэн, Д.Цэрэндагва, Ш.Болд, С.Сээсрэгдорж, С.Хишигжаргал. Уламжлалтын профессор Намралын Төмөрбаатар. Монголын анагаахын мэргэд XXXI боть. Улаанбаатар 2018, 24-30*
2. *Төмөрбаатар Н, Цэрэндагва Д, Хатанбаатар Ж. Төгсөлтийн дараах уламжлалт анагаах ухааны сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох нь Монголын уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэх нь тэслийн хэрэгжилт сэдэвт олон улсын бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ. 2005, 15-17*
3. *Төмөрбаатар Н. Монголын уламжлалт анагаах ухааны товч түүх болон өнөөгийн байдал, хэтийн төлөв. илтгэл. Япон. Осака, Киото. Токио. 2005.4.25, 2*
4. *Цэрэндагва Д. Зина С. Энхжаргал Н. Уламжлалт анагаахын ерөнхий мэргэжлийн эмчийн эмнэл зүйн удирдамж. УБ, 2004, 10-12*
5. *Төмөрбаатар Н. Хатанбаатар Ж. Цэрэндагва Д. Уламжлалт анагаахын суурь мэдлэг. УБ. 2006, 11-15*
6. *Монголын уламжлалт эмнэлгийн ажилтны лавлах бичиг. УБ, 1992, 3-4*
7. *Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого- 2017-2026 он. Монгол улсын засгийн газрын тогтоол. УБ, 2017, 4-6*
8. *Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, 34-38*
9. *Байгалмаа Р. Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн тусламж, эрэлт хэрэгцээ ба менежментийн зарим асуудал. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, 2010, 2-7*
10. *Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого. Нийгмийн эрүүл мэндийн эрх зүйн лавлах. УБ, 2003, 9-11*
11. *Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх үндсэн чиглэл (ЭМСайдын 1991 оны А/11-р тушаалын хавсралт) МҮЭ –ийн ажилтны лавлах. УБ, 1991, 6-8*
12. *Ц.Лхагвасүрэн, Ч.Чимэдрагчаа, Б.Дагвацэрэн, М.Амбага. Уламжлалтын их эрдэмтэн Академич Цэндийн Хайдав. Монголын анагаахын мэргэд. XXVII боть. Мөнхийн үсэг. Улаанбаатар хот. 2018, 55-58*
13. *Б.Дагвацэрэн, Ч.Чимэдрагчаа, Л.Батхүү, Д.Шинэтуяа, Д.Амарзаяа, А.Төгөлдөр, Б.Дэжидмаа, Б.Уганбаяр, Ч.Эрдэнэчимэг, А.Ану, Т.Халиунаа. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн-60 жил, Улаанбаатар хот, 2019, 28-30 "Мөнхийн үсэг" ХХК-д хэвлэв.*

Contribution of professor Tumurbaatar N to prepare the specialists of Mongolian medicine with Bachelor Degree

Uyanga TS[1], Baigalmaa R[2], Tserendagva B[1]

[1]MNUMS, ISoMM
[2]Khentii province, Hospital of Mongolian Medicine
E-mail: ubono2727@yahoo.com, Tel: 99152079

Abstract: To determine the contribution of Tumurbaatar N, the honored doctor and an academician of Mongolian medical academy, on preparing the specialist with bachelor degree of Mongolian medicine, content of the books, pictures, journals and newspapers which mentioned him and what are said about him on those were analyzed. As a result, the faculty of Mongolian medicine was founded in 1989 in the National Institute of medical sciences and began to train a combination of Western and Mongolian Medicine doctors. The National Institute of Medical sciences became the National University of Medical Sciences based on the decree of Mongolian government. It had the responsibility to train professionals to work in a methodical way during the transition of Mongolia to the democracy and the free market system, the development of pluralism, the establishment of a multi-party system, the introduction of family group practice and health insurance in health care, and the implementation of state policies to develop preventive medicine.Currently, the International School of Mongolian Medicine has expanded as one of the main school of the Mongolian National University of Medical Sciences. It started with 26 top students and the curriculum was processed and approved in 1989. It started implemented from 1990-1991 school year and the first three years of 1990-1993, the first five years of 1993-1998, and the first six years of 1994-2000 were developed and implemented. From the above, professor Tumurbaatar N established the first point of training the mongolian medicine doctors and dedicated his knowledge and hard work for the localization of the new branch of the health care system that developed the International School of Mongolian Medicine today.

Keywords: Professor Tumurbaatar N., Mongolian traditional medicine